

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Намсрайн Намдаг	Дугаар	L044
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Баяндун
Төрсөн газар	Дорнод аймгийн Баяндун сум	Төрсөн он	1933
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Угтамтэгчинлэн хийд, Дамбадаржаагийн хийд	Сүм хийдийн дугаар	ДОБД 029, ДОБД 028
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 5	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Дорнод аймгийн Баяндун сумын Угтамтэгчинлэн хийд, Дамбадаржаагийн хийд

-Танай нутаг оронд ямар сүм хийд байв?

Миний мэдэх юм юу байхав. Би 1933 оны хүн. Сая мэдээ орох гэж байхад хийд тарж байсан. Энэ Баяндун сумд хоёр хийд байгаа. Нэг нь Угтамын хийд, нэг нь Дамбадаржаагийн хийд. Дамбадаржаагийн энэ хийд 1900 онд барьсан гэдэг. Нөгөө нь 1870 онд барьсан гэдэг. Би бас та нарт худлаа хэлэх гэж байна. Би өөрийн нүдээр үзээгүй. Сонссон дуулснаа хэлэх гэж байна.

-Зүгээр зүгээр сонссон дуулсан зүйлийг л бичиж тэмдэглэж авч байгаа юм бид.

Угтамын хийд бараг 1830-аад оноос эхэлсэн гэдэг. Тав юм уу, зургаа. Зургадугаар Богдыг гэсэн байх аа. Энд хийд байгуулахуул яасан гээд хувилгаанаар Хэнтий аймгийн Биндэр сумаас Довчин гээшийг жаахан хүүхэд

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

залж авчирсан гэдэг. Тэгээд 1870-аад оноосоо урагш энд дацан барих болоод тэр дацангийг барихын тулд одооны хэлээр хандив тэр үеийн хэлээр бол бадар тийм хөрөнгө цуглуулсан байна. Баруун Хэнтий, урагшаа Буйр нуур, хойшоо Агын дацан, нааш Гүний хийд хүртэл явж бадар барьж хөрөнгө цуглуулсан. Агын дацангийн буриад нар бид монгол хүмүүс өгөх ёстой гээд өгсөн. Ингээд дуганыг хятад монгол хүмүүс барьсан. 1870 онд барьж дуусаад аравнайлах болсон. Аравнайд бадар өгсөн буриад нар тэр манай дацан байх гээд ирсэн. Ирээд чинь энэ оросын хар буриад нар ирлээ гээд халх өвгөд тэгж үзсэн. Тэгээд зодолдсон. Хувьсгал мандаад, хийд тартал нанчилдаж л байсан. Довчин тодроод эндээс эхнэр (Лхамсүрэн) аваад зун болохоор Хувилгаан довд зусдаг байсан.

Хийдэд хэдэн лам суудаг байсан вэ?

- 300 гаруй байх. 1000 арай ч биш.

-Хийд хэдэн оноос тарж эхэлсэн бэ?

1936 оноос эхэлж сүйдээд 1937 онд тарсан. Юмыг нь ийш тийш нь зөөсөн. Сүүлд Базаргүр гэдэг хүн сэргээсэн. Сэргээд олигтой явж байснаа больсон.

-Дамбадаржаагийн хийдийн тухай?

Зүүн хойд талд харуул байсан. Ван хүн байсан. 7-р Богдын лүндэн гарсан. Харуул хийд байгуулах зөвшөөрлийг нь авсан. 1905 оноос буриадүүд хойноос ганц нэгээрээ орж ирж эхэлсэн. Октябрийн хувьсгалаар 1917, 1918 оны үед буриадүүд орж ирээд энд нэг лүндэнтэй газар байдаг гэнэ гээд бид дацан барья гээд мод чулуу зөөлгөөд модон дацан барьсан.

-Дацанг хэдэн онд барьсан?

1918-1921 оны хооронд барьсан.

Хэдэн ламтай байсан бэ?

100 шахам лам байсан. Том лам нар нь 30-аад байсан.

- Дамбадаржаагийн хийд хэдэн дугантай байсан бэ?

Ер нь 3 дуганыг сонсч байсан.

Хийдийн мяндагтан лам нар, тэргүүн нь хэн гэдэг лам байсан бол?

Жамъян жорвон гэдэг лам удирддаг байсан. Жамъян жорвон Манба, Зод, Дүйнхор, Чойр, Жүд гэсэн 5 дацан байгуулсан. Дэг нь төвд дэгтэй байсан.

-Хийд хэдэн онд хаагдсан бэ?

1937 он гэхэд цөмийг хааж модон дацанг түлсэн.